



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/246

Хэрлэн сум

Монгол улсад Хүүхдийн байгууллага,
хөдөлгөөн үүсэж хөгжсөний 100 жилийн ойг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-ын 1.2, 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад хүүхдийн байгууллага, хөдөлгөөн үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ойн арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат), сумдын Засаг дарга бөгөөд Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн нарт үүрэг болгосугай.

3. Ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулан, хөтөлбөрийг батлуулж, захирамжийн хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Б.Өнөрцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГА, ХӨДӨЛГӨӨН ҮҮСЭЖ
ХӨГЖСӨНИЙ 100 ЖИЛИЙН ОЙН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Б.Өнөрцолмон	Аймгийн Засаг даргын орлогч
Ажлын хэсгийн дэд дарга:	Б.Түмэнжаргал	Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга:	Х.Уртнасан	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга
Гишүүд:	Н.Үнэнбат	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Э.Жавхлантөгс	Цагдаагийн газрын дарга
	С.Мөнхцэцэг	Боловсролын газрын дарга
	Д.Дашнамжилмаа	Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Т.Зулбаатар	Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Д.Цогт-Эрдэнэ	Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын дарга
	Г.Солонго	Биеийн тамир, спортын газрын дарга
	Д.Эрдэнэбаатар	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч
	З.Энхболд	Хэрлэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
	Э.Солонго	Хэрлэн сумын Хүүхдийн элч Сумдын Засаг дарга, Тосгодын Захирагч нар